61

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 16 өдөр Дугаар 3/13 Өвт

Бат-Өлзий сумын Засаг даргын 2020-2024 оны
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1."д", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээрзүйлийн 9.11.1, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бат-Өлзий сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг 2021 оны 2 сард багтаан иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж, сумын хөгжлийн жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (С.Амгалан)-д даалгасугай.

ДАРГА Д.ЦЭРЭНТОГТОХ

6218259775
ХТУ0608 9047551

My Dok D-A-4 togtool /ITKH/2020

0501001

62

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
3/13 дугаар тогтоолын хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн зорилго

Сумын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн хангаж, нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэж, орчин үеийн мэдээллийн технологи, шинжлэх ухааны ололтод суурилсан хөгжилтэй, бүтээлч ажилтай, орлоготой иргэдтэй, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар дундын давхаргын хамрах хүрээг өргөжүүлэн, оновчтой бүтэцтэй мал аж ахуй, аялал жуулчлалд суурилсан эдийн засагтай байхад оршино.

Хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөр, аймгийн Засаг даргын хөтөлбөрийг суурь зарчим болгон иргэдийг ажлын байраар хангах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, аялал жуулчлалыг дэмжих, хөдөө аж ахуйг хөгжүүлэх, эрчимжүүлэх зорилтуудыг тавьлаа.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим:

1.Төрийн болон хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, олон улсын хандивлагч байгууллагуудын төсөл, хөтөлбөрт уялдуулах.

2. Иргэд, айл өрх, албан байгууллагуудын идэвхи санаачилга, манлайллыг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах, байгаль хамгаалах, бэлчээрийн менежментийг зохистой болгох, орчны бохирдлыг бууруулахыг зарчим болгох.

Сумын Засаг дарга 2024 он дуустал энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бэлчээрийг, мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулах, байгалийн бохирдлыг эрс багасгах, сумын төвийн гэрэлтүүлэг, тохижилт, замын байдал эрс сайжирсан, багуудын төвд суурьшил, төвлөрөл бий болсон, аялал жуулчлалын гол маршрутаар дэд бүтэц хөгжсөн, орон нутгийн аж ахуйн нэгжүүд, иргэдийн бизнес хөгжиж өөрсдийгөө авч явах чадвартай болсон байна.

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Зорилт 1: Сумын эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, иргэдийн амьжиргаатай уялдуулан мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, газар тариалан, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг авч хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:

1.1.1. Малын гаралтай түүхий эдэд түшиглэж, ноос ноолуур, арьс, шир боловсруулах, элдэх, хүнсний ногоо боловсруулах цех байгуулах.

1.1.2. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж хэвшүүлэх.

1.1.3. Сумын онцлог, өв уламжлалыг харуулсан бэлэг дурсгал, гар урлал, үндэсний дээл хувцас, гоёл чимэглэл, уран хатгамал зэрэг брендэд чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих ажлын байр бэлтгэх.

1.1.4. "Бат-Өлзийд үйлдвэрлэв" худалдааны төв нээж, орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний худалдаалах боломжийг бүрдүүлж, цахим орчинд сурталчилан таниулах онлайн худалдааг хөгжүүлэх.

1.1.5. Байгалийн нөөцийг зохистой ашиглах, жимс жимсгэнэ, малын тэжээл тариалах чиглэлээр 300 га хүртэл талбайг эзэмшүүлж эргэлтэнд оруулна.

1.1.6. Сумын аялал жуулчлалын маршрутын дагуух зам, гүүр, дэд бүтцийн нөхцөлийг сайжруулах.

1.1.7. Гурван модны хөвөөний замыг засах.

Хүрэх үр дүн:

Аялал жуулчлалын маршрут, үзвэр нэмэгдэн, аялал жуулчлалаас иргэдэд орох орлого нэмэгдэнэ

1.2. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ

1.2.1. Сумын төв доторх хатуу хучилттай замын дутууг гүйцээх.

1.2.2. Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн авто замыг шинээр барих зураг төсвийг хийлгэж барьж эхлэх.

1.2.3. Наймаа булан, Өвт, Бэл хороололын үерийн далан барих.

1.2.4 Цаг уур, Наймаа булангийн 6 дугаар гудамжаас хойш, Өвтийн 17 дугаар гудамжнаас хойш, Бэлийн 11 дүгээр гудамжнаас хойш өргөн чөлөөнд гэрэлтүүлэг тавих.

1.2.5. Бүрэгтий багийн төвийг өндөр хүчдэлд холбох, худаг гаргаж суурьшилын бүс болгох.

1.2.6. Гэрэлтүүлэг, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээг хариуцах чиг үүрэг бүхий нэгж байгуулж, бүтэц орон тоо бий болгох.

1.2.7. Улаан голыг төмөр бетон хийцтэй хөлтэй, модон тавцантай гүүр барих.

1.2.8. Улиастай болон Улаан амны багийн төвийн барилга барих.

1.2.9. Сумын төвд цамхагт гэрэлтүүлэг 2-ыг барих.

1.2.10. Ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор үйлчилгээний цогцолбор төв барих. /үсчин, зурагчин, гоо сайхан, оёдол, фитнесс, халуун ус, саун, цайны газар ...../

1.2.11. Улаан ам багийн Улааны хэжүү, Амгалангийн хошууны замыг засварлах.

1.2.12. Зөрүүлэг багт нийтийн халуун ус барих.

1.2.13. Улаан ам, Бүрэгтий багийн төвд хүний эмчийн барилга барих, Улаан амны эмнэлгийг өрхийн эмнэлгийн статустай болгох. /Их эмчийн салбартай болгоно/

1.2.14. Ахмадын хөгжлийн төвийг шинээр барьж, ашиглалтанд оруулна.

1.2.15. Сумын төвийг танилцуулах, сурталчилах өндөрлөгтэй болгох.

1.2.16. Хүүхдийн "Хөдөлмөр амралтын зуслан" шинээр барьж ашиглалтанд оруулна.

1.2.17. Улс, аймгийн хамгаалалтад байдаг болон Дэлхийн өвд бүртгэлтэй түүх соёлын дурсгалтуудыг дэс дараалалтайгаар хашаажуулж, хамгаалалтыг сайжруулна.

1.2.18. Зүүн сөдөтийн Дунд халзангийн даваанд замыг засварлах.

1.3. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Зорилт: Байгаль цаг уурын нөхцөлд зохицсон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, бэлчээр ашиглалтыг сайжруулах, усан хангамжийг нэмэгдүүлэх төмс, хүнсний ногоогоор дотоодоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.3.1. Сумын төвийн тэжээлийн аюулгүйн нөөцийг орон нутгаас бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн өмчийн оролцоотойгоор аж ахуйн нэгж байгуулан газар тариалан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллуулна.

1.3.2. Сумын өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд "Атаршсан талбай"-г эргэлтэнд оруулж 200 га-аас доошгүй газарт ногоон тэжээл тариална.

1.3.3. Стандартын шаардлага хангасан "Мал нядалгааны цэг" байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин газрын асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллана.

1.3.4. Хүнсний ногооны зоорь байгуулах иргэн, аж ахуйн нэгжийн саналыг дэмжин газрын асуудлыг шийдэж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад анхаарч төсөл, хөтөлбөрөөр дэмжин хамтран ажиллана.

1.3.5. Хөдөө аж ахуйн агропарк барьж ашиглалтанд оруулна.

1.3.6. Сумын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор "Улиастай" багийн Улиастайн дэнжийн нам оруулга, Горхин дэнж, Улаан ам багийн Мухдаг, Бүрэгтий багийн төв, Дэндгэр, Билүүтийн хөндлөн, Баруун сөдөт, Зөрүүлэг багийн Урд Агуйт, Нарийн, Хойд агуйт зэрэг газарт худгуудыг шинээр гаргах.

1.3.7. Малын гоц болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл хүнстэй байх бодлогыг барьж Улиастай багийн Боймт, Шивэртий, Бөөрөг, Улаан ам багийн Бургас, Мухдагт мал тарилгын хашаа барина.

1.3.8. Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг тогтмолжуулж Бүрэгтий багийн Баруун сөдөтөд мал угаалгын ванн барина.

1.3.9. Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр малын эмч, нэгжүүдийн малын эмч нарыг хангах үйлчилгээг цахимжуулна.

1.4. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ЧИГЛЭЛЭЭР:

Зорилт 1: Гол ус, булаг шандны эхийг хамгаалах, аялал жуулчлалыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.1. Ойжуулалт, мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагыг дэмжиж, сумын төвийн засмал зам дагуу ногоон байгууламжтай болгох, мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.

1.4.2. Усны нөөц нэмэгдүүлэх, булаг, шандны эх хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх төслийг дэмжинэ.

1.4.3. Сумын хогны менежментийг сайжруулж, хог хаягдал дахин боловсруулах цех байгуулах, хог шатаах зуухтай болох.

1.4.4. Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хамгаалалтын менежментийг сайжруулна.

1.4.5. Төвхөн хийдийн угтах орчныг сайжруулна.

1.4.6. Үүртийн тохой-Төвхөн хийд, Улаанцутгалан-Бат-Өлзий гэсэн аялал жуулчлалын маршрутаар хөгжүүлнэ.

1.4.7. Найман нуур, Улаан голын Хүрхрээгийн мөсөнд авиралт, Өндөр хясааны сарлагийн фестиваль гэсэн тусгай сонирхлын аялалын маршрутыг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Суманд ногоон байгууламж, усны нөөц нэмэгдэж, иргэд таатай амьдрах орчинг бүрдүүлнэ.

1.5. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ

Зорилт 1. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхжсан гэр бүлийг төлөвшүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.5.1. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, нотолгоонд тулгуурлан гэр бүлийн боловсрол олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.5.2. Залуу гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана.

1.5.3. Гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулна.

1.5.4. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хөдөөгийн калуучуудыг хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягт суралцах явуулын үйлчилгээг нэвтрүүлж, залуучуудын оролцоог нэгмэгдүүлнэ.

ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЗОРИЛТУУД

Зорилт 1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн эмчилгээ үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.1.1. Сумын иргэдийг урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах хамрагдалтын хувийг 30%-д хүргэнэ.

2.1.2. Эмч, мэргэжилтнүүдийг үе шаттайгаар сургаж жил бүр 3 хүртэл хүнийг сургалтанд хамруулна.

2.1.3.Орчин үеийн дэвшилтэт рентген аппараттай болгоно.

2.1.4. Биохими болон шээсний анализатортой болгоно.

2.1.5. Төвийн дуудлагын авто машинтай болгоно.

2.1.6. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор алсын дуудлагын авто машины парк шинэчлэлт хийнэ.

2.1.7. Багийн эмч нарыг компьютер хэрэгслээр хангана.

2.1.8. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг шинээр барих.

2.1.9. Эмчийн байрыг засварлах ба шинээр эмчийн байр барина.

2.2. БИЕИЙН ТАМИР

Зорилт 1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор идэвхтэй амьдралын хэвшил тогтоох, гэр бүлийг дэмжих, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.2.1. Иргэдийн дунд “Миний нутаг сайхан” спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна.

2.2.2. Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг дэмжин биеийн тамирын арга зүйчтэй болгоно.

2.2.3. Хүүхэд залуучуудын спорт цогцолбор барина.

2.2.4. Өсвөр үеийг спортоор хичээллүүлэх ажлыг дэмжин жүдо бөх, чөлөөт бөх, бокс, шатар, даам, цана, гар бөмбөг, сагсан бөмбөг, теннисний төрлүүдээр шигшээ баг бүрдүүлнэ.

2.2.5. Олон улсын стандартад нийцсэн цанын бааз барина.

2.2.6. Жил бүр спортын нэрэмжит тэмцээнүүдийг зохион байгуулна.

2.2.7. Сумын хүний хөгжлийн индексийн үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагатай хамтран гаргана.

2.3. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БОДЛОГО ЗОРИЛТУУД.

Зорилт 1. Багш сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулан, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.3.1. Суманд 320 хүүхдийн сургуулийн барилга шинээр барина.
2.3.2. 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барина.
2.3.3. Спорт заал шинээр барина.
2.3.4. Сургуулийн дотуур байруудад их засвар хийнэ.
2.3.5. Багш хөгжлийн төвийг ширээ, сандалтай болгох.
2.3.6. Химийн иж бүрэн кабинеттай болгоно.
2.3.7. ЕБСургууль, 1 дүгээр Цэцэрлэгийн камержуулалтыг орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камертай болгоно.
2.3.8. ЕБСургуульд сэтгэл зүйчийн орон тоог бий болгоно. Мэргэшсэн сэтгэл зүйчээр хангана.
2.3.9. ЕБСургууль, СӨББ-уудыг хөгжим, техник хэрэгслээр бүрэн хангана.
2.3.10. СӨББ-уудыг 2 ээлжийн зөөлөн эдлэлээр хангана.
2.3.11. 1 дүгээр Цэцэрлэгийн хуучин байрны сантехникийг шинэчлэх.
2.3.12. 1 дүгээр Цэцэрлэгийн цэвэр бохир усны сантехникийн асуудлыг шийдвэрлэнэ.
2.3.13. СӨББ-уудыг хүүхдийн стандартад нийцсэн тоглоом наадгайгаар хангана.
2.3.14. Улаан ам багт суурь боловсрол олгох сургууль, 2 бүлэгтэй Цэцэрлэгийн байр барина.
2.3.15. "Чадварлаг багш" хөтөлбөрийн хүрээнд. Элсэлтийн ерөнхий шалгалтаар 800 оноо авсан багш, сурагчдыг урамшуулах, тэтгэлэгт хамруулах сумын дэд хөтөлбөр боловсруулж, ИТХ-аар батлуулан мөрдөн ажиллах.

2.3.16. Хүүхэд бүрийг сургуульд тэгш хамруулах боловсролын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж байгаа "Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь", "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершил боловсрол олгох" төслүүдийг хамтран хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. **Төрийн үйлчилгээ.**

Зорилт: Төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулж, мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд шаардлага хангахгүй, ёс зүйн алдаа гаргасан албан хаагчдад хариуцлага тооцож, төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1.1. Төрийн захиргааны байгууллагат чиг үүргийн шинжилгээ хийж давхардал, хийдлийг арилган бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоно.
3.1.2. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн сан бүрдүүлнэ.
3.1.3. Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга, хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагат ил тод, нээлттэй болгоно.

3.1.4. Нэг цэгийн үйлчилгээг стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангана. /ширээ, сандал, хаалт жигд/

3.1.5. ЗДТГ-ын барилга шинээр барих.

3.1.6. ЗДТГ-ын урд талбайг тохижуулах, машины зогсоол шинээр барих.

3.1.7. ЗДТГазар үйлчилгээний авто машинтай болох. /8-12 хүний суудалтай/

3.1.8. Дөрвөн машины багтаамжтай граж барих.

3.1.9. Шинэ ковштой болох.

3.1.10. Багийн Засаг дарга нарыг компьютер, ширээ сандлаар хангах.

Хүрэх үр дүн: Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, ажиллах орчин нөхцөл сайжирч, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна.

3.2. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Зорилт 1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.2.1. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөний дагуу сургалт, бэлтгэлийг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага олгоно.

3.2.2. Ерөнхий боловсролын бүх сургуулиудад цэрэг-эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг тогтмол хугацаанд хэрэгжүүлж, сумын цэрэг-эх орны сэдэвт хөшөө, дурсгалын зүйл, бодит түүхийн ой санамжийг сэргээх, илэрхийлэх санал санаачилгуудыг дэмжиж ажиллана.

3.2.3. Сумын гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээг аюулын төрөл бүрээр эрх бүхий байгууллагаар хийлгэнэ.

3.2.4. Сумын гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг чадавхжуулж, зарим тоног төхөөрөмжөөр хангана.

ДӨРӨВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1.1. “Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.1.2. Архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах чиглэлээр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хүчирхийллээс хамгаалах байр барих.

4.1.3. Гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.1.4. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд төрийн зарим байгууллагуудыг татан оролцуулж, мал бүрийг бүртгэлжүүлэх, мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулах, малчдын бүлэг, нөхөрлөлийг чадавхжуулах цогц арга хэмжээ авах.

4.1.5. Цагдаагийн кабон байрны урсгал засарыг хийх.

Хүрэх үр дүн: Гэмт хэргийн гаралтыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Тав.“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ,

НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

Зорилт 1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.1.1. Халдварт цар тахлын үед нийгмийн хамгааллын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

5.1.2. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

5.1.3. Цар тахлын үед түлээ, нүүрс, хүнсний хомсдолд орж болзошгүй иргэдэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч, дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

5.1.4. Түлээ, нүүрс, хүнс, шатахуун зэрэг өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл, савлалт, хүргэлт, тараалт, борлуулалтыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, үнийн өсөлт үүсэхээс сэргийлж ажиллана.

5.1.5. Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа, сургалтийн үйл ажиллагаа зохион байгуулна.

5.1.6. Отор нүүдэл хийж байгаа малчдад эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг хүргэх, мал сүргээ онд оруулах талаар отор хүлээн авагч аймаг, сумдтай хамтран ажиллах замаар орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хадгална.

5.2."Ковид-19" халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.2.1. Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн хандив тусламжийг шаардлагатай газар, объектуудад хуваарилах ба сумын Засаг даргын нөөц сангийн гамшгаас хамгаалах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

5.2.2. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, томуугийн вакцинд төрийн албан хаагчид, өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, пост штабт ажиллаж байгаа иргэдийг хамруулна.

5.2.3. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд хамруулна.

5.2.4. Халдварт өвчний голомтод ажилласан албан хаагчдад урамшуулал, дэмжлэг олгоно.

5.2.5. Коронавируст халдварын батлагдсан тохиолдолд хэрэглэгдэх вирусийн эсрэг эм, сонгомол антибиотик, үрэвслийн эсрэг эм, тариа, оношлуур, хамгаалах хэрэгслэлийн нөөцийг бүрдүүлнэ.

5.2.6 Тархвар судлал, халдварт, зоонозын халдварт өвчний чиглэлээр эмч мэргэжилтнийг бэлтгэх, сургаж, чадавхжуулах, орон тоог нэмэгдүүлнэ.

5.2.7. Сумын Эрүүл мэндийн төвийн халдвартын тасгийг өргөжүүлж, байрны асуудлыг шийдвэрлэнэ.

5.2.8 Цар тахлын үед ажиллах тусгаарлах болон тусгаарлан ажиглах байрыг томилгоожуулж, бэлэн байдлыг хангана.

5.2.9. Халдварт хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах орчин үеийн дэвшилтэт технологит суурилсан байгууламжийг бэлэн болгоно.

5.2.10 Хорио цээрийн дэглэмийн үед хэмнэгдсэн зардлыг тооцож, нэн шаардлагатай арга хэмжээнд сумын Онцгой комиссын шийдвэрийг үндэслэж, зарцуулна.

5.2.11 Сурагчдад цахимаар явуулах хичээлийн цагийг зохистой хэмжээнд хүргэхийн зэрэгцээ, сургалтын хөтөлбөрийн хоцрогдол гаргахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.2.12. Сургууль, цэцэрлэг бүр цахим, теле хичээл бэлтгэн, технологийн сан бүрдүүлж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл сургалтыг тасралтгүй үргэлжлүүлж, танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин, тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулна.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь 5 зорилт бүхий 113 арга хэмжээний ажил төлөвлөсөн.

-oOo-